

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ
2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ
3. ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ
4. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ
5. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
6. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
7. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
8. ТӨСВИЙН ТУХАЙ
9. ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ
10. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ
11. ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ
12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ
13. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН
ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД
ХӨРӨНГИЙН ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “онцгой байдлын алба” гэснийг “онцгой байдлын байгууллага” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “иргэний хамгаалалтын алба” гэснийг “онцгой байдлын байгууллага” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтын “иргэний агаарын хөлөг,” гэсний дараа “гамшиг, ослын үед агаараас эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалттай агаарын хөлөг” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 5.13 дугаар зүйлийн 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг:

“7.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж хэрэгжүүлээгүй, хууль тогтоомжид заасны дагуу тодотгол хийгээгүй бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал болон аюулын үед хүч хэрэгсэл дайчлан гаргах шийдвэрийн дагуу өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа барилга байгууламж, газар, техник хэрэгсэл, бараа материалыг ашиглуулахаас зайлсхийсэн, эсхүл саад учруулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд саад учруулах, хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, сэтгэл санааны дарамт учруулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Салбарын хэмжээнд албаны хуулиар хүлээсэн чиг үүрэг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилсүгэй.

“4.Энэ зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 дахь хэсэгт зааснаас бусад байдлаар Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн, эсхүл тус хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл улсын байцаагчийн шийдвэр, шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюултай тэмцэх” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7 дахь заалтын “5.13 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6” гэсний дараа “7, 8, 9, 10” гэж, “15.9 дүгээр зүйлийн” гэсний дараа “1,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“13.1.30.улсын нөөцийн зориулалтаар худалдан авсан, эсхүл борлуулах нөөцийн бараа, материал.”

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “зэвсэгт хүчин,” гэсний дараа “онцгой байдал,” гэж, 13.1.6 дахь заалтын “иргэний агаарын хөлөг,” гэсний дараа “гамшиг, ослын үед агаараас эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалттай агаарын хөлөг,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “болон бүх нийтийн” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2 дахь заалтын “байгалийн гамшгийн үр дагаврыг” гэснийг “гамшгийн хор уршгийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын “гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ” гэснийг “гамшгийн эрсдэлийн үнэлгээ” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “гамшгаас хамгаалах алба” гэснийг “онцгой байдлын байгууллага” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “онцгой байдлын газраар” гэснийг “онцгой байдлын байгууллагаар” гэж, 24 дүгээр зүйлийн 13 дахь хэсгийн “онцгой байдлын албанд” гэснийг “онцгой байдлын байгууллагад” гэж, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “онцгой байдлын газар” гэснийг “онцгой байдлын байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын “онцгой байдлын газраар” гэснийг “онцгой байдлын байгууллагаар” гэж, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “онцгой байдлын газар” гэснийг “онцгой байдлын байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “онцгой байдлын албаны” гэснийг “онцгой байдлын байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“7.2.12.байшин, орон сууц болон орчны газрын галын аюулгүй байдлыг хангуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг баг, хорооны Засаг дарга болон бусад холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ